



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 5/18

Баян-Овоо

**Ч.Бат-Эрдэнэд сахилгын шийтгэл
оногдуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.3, 123.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөө аж ахуйн тасгийн дарга Чулууны Бат-Эрдэнэ нь ажлын цагаар архи ууж ажил тасалж, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан тул сахилгын шийтгэл оногдуулсугай.

2.Ч.Бат-Эрдэний цалинг 1 (нэг) сарын үндсэн цалингийн 20 (хорь) хувиар бууруулан тооцож олгохыг нягтлан бодогч (Д.Энхзул)-д даалгасугай.

3.Ч.Бат-Эрдэнэд гаргасан зөрчлөө арилгаж ажиллахыг сануулж, энэхүү алдааг давтан гаргасан тохиолдолд шууд ажлаас халах болохыг хатуу анхааруулсугай.

ДАРГА



Д.ГЭРЭЛМАА

020000118